

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн эмч, эмнэлгийн бусад мэргэжилтэнд тавигдах шаардлага

1. Зөвшөөрлийн хугацаа дуусаагүй байх
2. ЭМС-ын 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/98 дугаар тушаалын 6.2, 6.3, 6.5-д заасны дагуу жил бүрийн багц цагийг бүрэн биелүүлсэн байх
 - 6.2-д “Зөвшөөрөл бүхий хүний их эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эм зүйч жил тутам 6 багц цаг, хүний бага эмч, эх баригч, сувилагч, эм найруулагч жил тутам 3 багц цагийн багтаамж бүхий сургалтанд хамрагдана”.
 - 6.3-д “Аймгийн төвөөс 100 ба түүнээс джжш км-т алслагдсан нутагт ажиллаж байгаа бол их эмч, эм зүйч жил тутам 4 багц цаг, сувилагч, эм найруулагч, бага эмч, эх баригч жил тутам 2 багц цагийг бүрдүүлнэ”.
 - 6.5-д “Эмнэлгийн мэргэжилтний жил тутам биелүүлэх багц цагийн 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж байгаа мэргэжлийн чиглэлээр, бусад нь ёс зүй, харилцаа хандлага, хууль эрх зүй, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр байна”.
3. ЭМС-ын 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/98 дугаар тушаалын 5.6.4 дэх заалтыг зөрчөөгүй байх
 - 5.6.4-д “ Нэг жилээс дээш хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлээгүй” тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр зөвшөөрлийг хүчингүй болгоно.

Жич:

- Хосолсон мэргэжил эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн төрөл солиулах тохиолдолд тухайн чиглэлийн дагуу зөвшөөрлийн шалгалт өгнө.